

Австрали-Монголын эрдэс баялгийн салбарын хамтын ажиллагааны хөтөлбөр АМЕП 2

ТЭЗҮ харьцуулалт

Стив Гемелл

ТЭЗҮ ҮНДЭСЛЭЛ БОЛОВСРУУЛАХ ОЛОН УЛСЫН СТАНДАРТ

- ТЭЗҮ-ийг тухайн төслийг санхүүжүүлэх асуудлыг шийдвэрлэх зорилгоор боловсруулдаг
- Судалгааны агуулга, загварыг зээлдүүлэгч, хөрөнгө оруулагчийн шаардлагад нийцүүлэн өөрчлөж ирсэн
- Засгийн газар, төрийн захиргааны байгууллагууд ТЭЗҮ-ийг боловсруулах стандарт журам, түүнийг батлах зохицуулалт хийдэггүй
- Гэхдээ, ТЭЗҮ-ийг Ашигт малтмал олборлох ашиглалтын тусгай зөвшөөрөл хүсэх өргөдөл гаргахуйц хэмжээний ажил хийгдсэн байна гэдгийг батлах зорилгоор зарим хууль эрх зүйн нөхцөлд нотолгоо болгон ашигладаг

СУДАЛГААНЫ ОЛОН УЛСЫН ЗАГВАР

- Цаг хугацааны явцад тайлангийн загвар ТЭЗҮ-ийн хувьд стандарчлагдах хандлагатай байгаа хэдийч багцаалсан үнэлгээ (scoring), урьдчилсан техник-эдийн засгийн үнэлгээний (prefeasibility study) хувьд энэ хандлага бага ажиглагддаг
- Дээрх зарчмаар, ТЭЗҮ-ийн байж болох агуулга (далайц) болон нарийвчлал (гүн) нь нэмэгдэн стандарчлагдах хандлагатай байна
- Судалгааны далайц, гүнийг илэрхийлэхийн тулд Америкийн төсөвч инженерүүдийн холбооны (АТИХ: American Association of Cost Engineers-AACE) ангиллыг өргөн хэрэглэдэг
- Судалгааны загвар, агуулгыг төслийн үзүүлэлтүүдэд тохируулан өөрчилдөг, ингэснээр төслийн эрсдлийг бодитоор үнэлэх боломж хадгалагдана

АТИХ АНГИЛАЛ

- 5 – Багцаалсан үнэлгээ. Үр дүн нь “таамагласан”-аас “багцаалсан” түвшинд үнэлэгдэнэ.
- 4 – Урьдчилсан ТЭЗҮ. Үр дүн нь “ойролцоо”-оос “урьдчилсан” түвшинд үнэлэгдэнэ.
- 3 – ТЭЗҮ. Үр дүн нь “тооцоолгдсон”-оос “бүрэн” түвшинд үнэлэгдэнэ.
- 2 – Инженерийн зураг төсөл (Definitive Engineering). Үр дүн нь “бүрэн” түвшинд үнэлэгдэнэ.
- 1 – Хөрөнгийг бүртгэх зорилгоор “Баригдах/Баригдсан” (‘As Built’) түвшинд зардлыг тооцно.

НАРИЙВЧЛАЛЫН ТҮВШИН

- Багцаалсан үнэлгээ (Scoping Studies): +/- 30 to 35%
- Урьдчилсан ТЭЗҮ (Prefeasibility Studies): +/- 20 to 25%
- ТЭЗҮ (Feasibility Studies): +/- 10 to 15%
- Инженерийн зураг төсөл (Definitive Engineering): +/- 5 to 10%

ТООЦОГДООГУЙ ЗАРДАЛ

- Багцаалсан үнэлгээ: нийт зардлын 25 - 35% (нийт төслийн зардлаар үнэлсэн, тооцоолсон)
- Урьдчилсан ТЭЗҮ: нийт зардлын 15 - 25% (талбай/муж /хэсгээр тооцоолсон юмуу нарийвчилсан)
- ТЭЗҮ: нийт зардлын 10 - 15% (худалдаа болон мужаар нарийвчилсан)
- Инженерийн зураг төсөл: нийт зардлын 5 - 10% (эцсийн, худалдаа болон мужаар)
- Нэмэлтүүд: ажиллаж байгаа үйлдвэрлэл дэх төсөл (5% хүртэл), шинэ технологи (5% хүртэл)

МОНГОЛЫН НӨХЦӨЛ

- Дүн шинжилгээ хийхэд харьцуулах болон хязгаарлах нөхцлүүдийн үндэс суурь юу вэ?
- ТЭЗҮ-ийн зорилго: санхүүжүлэлт үү, хууль эрх зүйн зохицуулалт уу?
- ЗГ нь зохицуулагч уу, (хэсэгчилсэн) эзэмшигч үү, эсвэл аль алин нь уу?
- Тайлангийн цар хүрээ, гүн
- ТЭЗҮ-ийн хүчинтэй байх хугацаа хязгаарлагдмал
- Уулын ажлын төлөвлөгөөний хэрэглээ

ТЭЗҮ-ТЭЙ ХОЛБООТОЙ АСУУДЛУУД

- Агуулга нь нарийвчлалын шаардлагатай түвшинг хангаж байх ёстой
- Эрсдлийн иж бүрэн дүн шинжилгээ заавал хийгдэх
- Биет, орлого, зарлагын хуваарийг цаг хугацааны шатлалаар нарийвчлан тооцоолсон байх ёстой
- Бэлэн мөнгөний урсгалыг задаргаагаар нарийвчлан тогтоосон байх ёстой (Cash flows must be sophisticated)
- Нарийвчлалын шаардлагатай түвшинд хүрэх үүднээс зардлын тооцоог нарийвчлан гүйцэтгэсэн байх ёстой
- ТЭЗҮ-д тооцсон зардлуудыг баталгаажуулах нэмэлт баримт бичгүүдийг хавсаргаж нотолгоо болгоно